# ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Сумын Засаг даргын 2017 оны А/51 тоот захирамжийг үндэслэн Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 1 дүгээр багийн нутаг давсгэрт дараах байршилд, Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зарлаж байна.

1. 1 дүгээр баг, 14 дүгээр байрны хойд талд “Эмийн сан”-гийн зориулалтаар 0.12 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэх.
2. Төсөл сонгон шалгаруулалтын материалыг хүлээн авах хугацаа : 2017 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 12.00 цаг хүртэл бүртгэж, битүүмжилсэн байдлаар Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын 213 тоот өрөөнд хүлээн авна.
3. Төсөл сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалыг нээх хугацаа : Төсөл сонгон шалгаруулалтын материалыг 2017 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 15.00 цагт сумын Засаг даргын захирамжаар томилогдсон комисс оролцогчдын төлөөллийг байлцуулан Засаг даргын Тамгын газрын 203 тоот өрөөнд нээнэ.
4. Эзэмшүүлэх газрын байршил:




5. Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний үнэ: 5.000 төгрөг.
6. Төсөл сонгон шалгаруулах үндсэн үзүүлэлтүүд, архитектур төлөвлөлтийн даалгавар, гэрээний ерөнхий нөхцөл, техникийн ерөнхий нөхцөл, барилга барих хугацаа, барилга байгууламжийн төлөвлөгөө, тохижилтод тавигдах шаардлага, төсөл сонгон шапгаруулах журмаар олгох газрын хил хязгаар, заагийг харуулсан зураг, схем зэргийг төслийн баримт бичигт хавсаргасан байна.
7. Нэмэлт шаардлага : Эм худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй, 5-аас доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн байна.
8. Төслийн баримт бичгийг бичгээр хүсэлт гаргаж, эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 200.000 төгрөгөөр Шивээговь сумын Газрын даамал 213 тоот өрөөнөөс авна.

**Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг Засаг даргын Тамгын газар,**

**тоот Харилцах утас: 70546204, 70543387, 88012061**

**2017.06.09**